

## ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

### “ХӨВСГӨЛ АЛТАНДУУЛГА” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД

#### Санхүүгийн Тайлангийн Аудитын Тайлан

#### Хязгаарлалттай дүгнэлт

Бид, “ХӨВСГӨЛ АЛТАНДУУЛГА” Хувьцаат Компанийн (цаашид Компани гэх) 2019 оны 12 сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тодруулга, тэмдэглэлээс бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр, Компанийн 2019 оны 12 сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, энэ өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-ын дагуу, Хязгаарлалттай дүгнэлтийн үндэслэл, Тасралтгүй үйл ажиллагаа явуулах зарчимтай холбоотой материаллаг тодорхойгүй байдал хэсэгт дурдсанаас бусад материаллаг зүйлийг хамруулан, үнэн зөв толилуулсан байна.

#### Хязгаарлалттай дүгнэлтийн үндэслэл

Компани нь 2019 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн ТУЗ-н хурлын тогтоолын дагуу 783,545 ширхэг энгийн хувьцааг 531,648 мянган төгрөгийн өртөгтэй эргүүлэн худалдан авсан бөгөөд уг энгийн хувьцааг гаргах үед буюу 2018 онд стратегийн хөрөнгө оруулагчдын өмнө буцаан худалдан авах үүрэг хүлээсэн байсан байна. 2018 онд нэмж гаргасан хувьцаанаас буцаан худалдан авах нөхцөлтэй хувьцаа нь 1,164,706 ш буюу хувьцааг гаргах үеийн ханшаар 1,500,000 мянган төгрөг бөгөөд уг хувьцааны гаргалт болон эргүүлэн худалдан авалттай холбоотой бүртгэл тайлагналыг СТОУС 9 Санхүүгийн хэрэглүүр, НББОУС 32 Санхүүгийн хэрэглүүрийн толилуулга стандартуудын дагуу тус тус бүртгэж тайлагнаагүй байна /Тодруулга 21/.

Бид аудитаа Аудитын олон улсын стандарт(АОУС)-ын дагуу хийсэн. Эдгээр стандартын дагуу хүлээх хариуцлагаа энэхүү тайлангийн Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага хэсэгт харуулсан. Бид Нягтлан бодогчдын ёс зүйн олон улсын стандартын зөвлөл (НБЁЗОУСЗ)-өөс гаргасан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм болон Аудитын тухай Монгол улсын хуулиар санхүүгийн тайлангийн аудитад тавигддаг ёс зүйн шаардлагын дагуу компаниас хараат бус бөгөөд хууль болон НБЁЗОУСЗ-өөс гаргасан дүрмийн шаардлагын дагуу тавигддаг ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн. Бидний олж авсан аудитын нотолгоо нь аудитын хязгаарлалттай дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэж найдаж байна.

#### **Тасралтгүй үйл ажиллагаа явуулах зарчимтай холбоотой материаллаг тодорхойгүй байдал**

Компани нь 2019 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар 2,504,256 (2018: 3,266,948) мянган төгрөгийн хуримтлагдсан ашигтай, 5,740,273 (2018: 6,038,142) мянган төгрөгийн богино хугацаат өр төлбөртэй, 5,379,049 (2018: 7,312,767) мянган төгрөгийн эргэлтийн хөрөнгөтэй ажилласан байна. Компанийн төлбөрийн чадварын үзүүлэлт зохистой мэт харагдаж байгаа боловч Тодруулга 2-т дурдсан хугацаа хэтэрсэн зээл, болзошгүй өр төлбөр, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлт зэргээс шалтгаалан Компанийн тасралтгүй үйл ажиллагаа явуулах чадварт эргэлзээ төрүүлэхүйц нөхцөл үүсэж болзошгүй байна.

Бид ирэх 12 сарын хугацаанд Компанийн тасралтгүй үйл ажиллагаа явуулах зарчимтай холбоотой материаллаг тодорхойгүй байдал үүсэж болзошгүй байгаа талаар удирдлага болон хувьцаа эзэмшигчид мэдэгдсэн бөгөөд Компанийн удирдлага болон хувьцаа эзэмшигчид Компанийн удирдлага болон засаглал хариуцсан этгээдүүд нь богино хугацаат зээлүүдийн хугацааг нь сунгах, бэлэн мөнгөөрх борлуулалтыг нэмэгдүүлэх, эргэлтийн хөрөнгөнөөс эргэлтийн бус хөрөнгийг санхүүжүүлэхгүй байх зэрэг арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлснээр Компанийн төлбөрийн чадвар сайжирна гэж үзэж байгаа тул Компанийг 2019 оны 12 сарын 31-ний өдрөөс хойших 12 сарын хугацаанд тасралтгүй үйл ажиллагаа явуулах чадвартай гэж үзэн санхүүгийн тайлангуудыг бэлдсэн болно. Компанийн тасралтгүй үйл ажиллагаа явуулах чадвартай холбоотой дүгнэлтийн хэлбэрт өөрчлөлт оруулахгүйгээр Тодруулга 2-т энэ талаар дэлгэрэнгүй дурдсан болно.

#### **Аудитын гол асуудлууд**

Бидний мэргэжлийн үнэлэмжээр аудитын гол асуудлууд гэж тайлант жилийн санхүүгийн тайланд хийсэн аудитад хамгийн их ач хөлбогдолтой, нөлөө бүхий асуудлууд юм. Санхүүгийн тайланд хийсэн аудитын хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба эдгээр асуудлын талаар тусад нь дүгнэлт гаргаагүй. Бид дараах асуудлыг гол асуудал гэж тодорхойлсон.



- Компани нь хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн буюу газар тариалан эрхэлж хүлээн авсан буудайг хүлээн авалтын цэг дээр бодит үнэ цэнээс борлуулалтын зардлыг хассан дүнгээр бүртгэх ёстой боловч ургуулсан үр тария болон бусад дайвар бүтээгдэхүүний өртгийг өртгийн загвар ашиглан бүртгэсэн байна. Бид аудитын явцад газар тариалангийн үйлдвэрлэлийн зардлыг зөв хуримтлуулан бүртгэсэн эсэх, хурааж авсан буудайны өртгийг зөв тооцоолсон эсэхийг төлөвлөсөн горимуудын дагуу шалгахад ямар нэгэн материаллаг алдаа илрээгүй.
- Мөн таваарын биологийн хөрөнгө буюу борлуулах зорилготой эсвэл ирэх жилийн тариалалтад үр болгон ашиглах зориулалттай буудайг тайлант үеийн эцэст тухайн өдрөөрх бодит үнэ цэнээс борлуулалтын зардлыг хассан дүнгээр хэмжээгүй байна. Бид нийт хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн болон таваарын биологийн хөрөнгийн бодит үнэ цэнийг тооцоолж Компанийн удирдлага, засаглал хариуцсан этгээдүүдэд захидал хүргүүлэн цаашид газар тариалан болон гурилын үйлдвэрлэлийн сегментийн бүртгэлийг тусад нь хөтөлж няглан бodoх бүртгэлийн бодлогодоо өөрчлөлт оруулахыг зөвлөсөн.
- 2019 оны үндсэн хөрөнгө, бараа материалын эцсийн үлдэгдлийн оршин буй эсэхийг баталгаажуулахдаа Монгол улсад үүссэн онцгой нөхцөл байдлын улмаас тухайн байршилд очиж тооллогод оролцох боломжгүй байсан тул сонгогдсон хөрөнгүүдийн хувьд аудитын бусад горимуудыг хэрэгжүүлж зайнаас тооллогын процесст ажиглалт хийсэн /Тодруулга 12, 17/.

### **Удирдлага болон засаглах удирдлагын санхүүгийн тайланда хүлээх үүрэг хариуцлага**

Удирдлага нь СТОУС-ын дагуу эдгээр санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах хариуцлага хүлээх бөгөөд мөн залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжтой болгоход зайлшгүй чухал гэж өөрийн тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланг гаргахдаа удирдлага Компанийн үйл ажиллагааг зогсоох юм уу татаан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудаа гаргахдаа удирдлага тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах компанийн чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, няглан бodoх бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.


Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлага хүлээдэг.

## **Санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг хариуцлага**

Бидний зорилго санхүүгийн тайлангууд нь бүхэлдээ залилан юм уу алдаанаас үүдэлтэй материаллаг буруу илэрхийллээс анgid эсэх талаар ул үндэслэлтэй баталгаа олж авах, өөрийн дүгнэлтийг багтаасан аудиторын тайлан гаргахад байдаг. Ул үндэслэлтэй нотолгоо нь баталгааны өндөр түвшин боловч АОУС-ын дагуу хийгддэг аудит нь оршин байгаа материаллаг буруу илэрхийллийг цаг ямагт илрүүлж байна гэсэн амлалт өгдөггүй. Буруу илэрхийлэл нь залилангаас эсвэл алдаанаас үүсэж болох ба дангаараа юм уу нийлээд материаллаг болж эдгээр алдаа нь санхүүгийн тайлангууд дээр суурилан хэрэглэгчийн гаргах эдийн засгийн шийдвэрт нэлөөлөх магадлалтай гэж үзсэн үед материаллаг буруу илэрхийллийг авч үзнэ.

АОУС-ын дагуух аудитын нэг хэсэг байдлаар бид мэргэжлийн үнэлэмж ашиглаж аудитын ажлын явцад мэргэжлийн үл итгэх хандлагыг баримталдаг. Бид мөн:

- Залилан эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдэлийг тодорхойлж, түүнийг үнэлэн уг эрсдэлд тохирохуйц аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж өөрсдийн дүгнэлтийнхээ үндэслэл болохуйц хангалттай, зохистой аудитын баримт нотолгоог олж авдаг.  
Залилангаас үссэн материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үссэн буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэлээс харьцангуй их байдаг. Учир нь залиланд хуйвалдаан, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу илэрхийлэх болон дотоод хяналтыг орхигдуулах явдлууд багтсан байж болно.
- Компанийн дотоод хяналтын үр ашигтай байдалд дүгнэлт өгөх зорилгоор бус тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулахын тулд аудитын ажилтай холбоотой дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг.
- Ашигласан нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын нийцэмжтэй байдал, нягтлан бодох бүртгэлийн тооцооллын ул үндэслэл, удирдлагын хийсэн тооцоолол болон холбогдох тодруулгыг үнэлдэг.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, мөн олж авсан аудитын баримт нотолгоонд үндэслэн нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал оршин байгаа эсэхийг тодорхойлдог. Хэрэв материаллаг хэмжээний тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгад анхаарал хандуулах эсвэл ийм тодруулга хийх нь хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэлх олж авсан аудитын баримт нотолгоондоо үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал, эсвэл нөхцөл байдал компани тасралтгүй байх зарчмын



дагуу үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах боломжгүй болгоход хүргэж болно.

- Тодруулгыг багтаагаад санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг үнэлж санхүүгийн тайланд үнэн зөв толилуулгын шаардлагыг хангахуйц байдлаар гол гол ажил гүйлгээ, үйл явдлуудыг илэрхийлсэн эсэхийг тодорхойлдог.

Бид бусад асуудлуудын дундаас аудитын ажлын төлөвлөсөн хамрах хүрээ, цаг хугацаа болон аудитын явцад тодорхойлсон дотоод хяналтын аливаа мэдэгдэхүйц доголдлыг багтаагаад аудитын илэрсэн томоохон асуудлуудаар засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдтэй харилцсан.

Бид хараат бус байдлын тухай холбогдох ёс зүйн шаардлагуудад нийцсэн мэдэгдлээр засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдийг хангадаг ба мөн бид тэдгээр хүмүүстэй бүх харилцаа холбоо болон шаардлагатай гэж үзвэл харуул хамгаалалт зэрэг бидний хараат бус байдлын хүрээнд бодолцож үзвэл зохих асуудлуудаар харилцсан.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдтэй харилцсан асуудлуудаас тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн нөлөөтэй асуудлуудыг тодорхойлж тэдгээр асуудлаа аудитын гол асуудлууд гэж үздэг.

Хууль, дүрэм журмаар аливаа асуудлыг олон нийтэд мэдээлэхийг хориглосон эсвэл тун ховор тохиолдолд аудиторын тайландаа аливаа асуудлаар харилцах нь тухайн харилцаанаас хүртэх олон нийтийн үр өгөөжөөс илүү сөрөг үр дагавартай гэж учраас аудиторын тайландаа харилцахгүй байх нь зүйтэй гэж үзсэнээс бусад тохиолдолд тэдгээр асуудлыг аудиторын тайландаа тодорхойлдог

#### **Бусад асуудал**

Энэхүү тайланг өөр ямар нэгэн зорилгоор биш, Компанийн хувьцаа эзэмшигчдэд зориулан гаргасан бөгөөд бусад этгээдэд зориулагдаагүй болно. Бид энэхүү тайлангийн хүрээнд гуравдагч этгээдийн өмнө хариуцлага хүлээхгүй болно.



Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Олимпын гудамж 7/3 байр, 7 давхар 701 тоот.

Утас: 976-70150013, И-мэйл: [info@moore-mongolia.mn](mailto:info@moore-mongolia.mn)